

АЙМГИЙН ИТХ-ЫН ДЭРГЭДЭХ ИРГЭНИЙ ЗӨВЛӨЛӨӨС ИРҮҮЛСЭН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖИЙН ХҮРЭЭНД ТӨВ АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗРААС 2020 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛД ХИЙСЭН АЖЛЫН БИЕЛЭЛТ

2020.07.20
сум

Зуунмод

№	Зөвлөмж	Зөвлөмжийн хүрээнд хийх ажил	Хугацаа	Биелэлт	Хувь
1	Төв аймгийн цагдаагийн газрын 2019 оны үйл ажиллагааны тайланг бүх сумдад өдөрлөг, уулзалт, мэдээллийн хэрэгслээр хүргэж, тайлантай холбогдуулан орон нутаг, иргэдээс гарсан санал шүүмжлэлийн мөрөөр тодорхой ажил зохион байгуулах	Цагдаагийн газрын 2019 оны үйл ажиллагааны тайланг бүх сумдад өдөрлөг, уулзалт, мэдээллийн хэрэгслээр хүргэж, тайлантай холбогдуулан орон нутаг, иргэдээс гарсан санал шүүмжлэлийн мөрөөр тодорхой ажил зохион байгуулах талаар сумдын хэсгийн төлөөлөгч нарт үүрэг өгч, хэрэгжилтийг хангах	2-р сард	Цагдаагийн албаны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6 дахь хэсэг, Хууль зүйн сайдын 2014 оны А/89 дүгээр тушаалаар баталсан “Иргэний зөвлөл, оршин суугчдад цагдаагийн байгууллагын тайлан тавих журам”-ын дагуу 2019 оны үйл ажиллагааны тайланг 2020 оны 01 дүгээр сарын 14-ны өдөр Зуунмод суманд тавьсан. Цагдаагийн газраас 2019 онд хийсэн ажлын товч тайланг Цагдаагийн газрын вэб сайт, фейсбүүк хуудас, сумдын вэб сайтад байршуулж иргэд, олон нийтэд сурталчилж байна.	100
2	Сумдын олон нийтийн цагдаагийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, сургаж мэргэшүүлэн	Олон нийтийн цагдаагийн ажилтныг сурган дадлагажуулах, өдөр тутмын үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах	Тухай бүр	Аймгийн хэмжээнд 18 суманд 19 олон нийтийн цагдаагийн ажилтан ажиллахаас 10 суманд 11 олон нийтийн цагдаагийн ажилтан томилогдон ажиллаж байна. Олон нийтийн цагдаагийн ажилтны цалин хангамж	70

	чадавхжуулах			бага, зарим сумд сар бүр цалин урамшууллыг олгохгүй байгаагаас уг ажлын байранд иргэд тогтвортой ажиллахгүй байна.	
3	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд нутгийн удирдлагын байгууллагуудтай хамтран ажиллаж, иргэд олон нийт цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны үр дүнг сайжруулах	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг тооцох	Улирал бүр	<p>Тус Цагдаагийн газарт 2020 оны эхний хагас жилийн байдлаар 423 гэмт хэрэг бүртгэгдэж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 11 нэгжээр буюу 2,7 хувиар өссөн, зөрчил 25219 бүртгэгдэж 3369 нэгжээр буюу 11,8 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Гэмт хэргийн илрүүлэлт 48 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 3,7 хувиар өссөн байна.</p> <p>Гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, урьдчилан сэргийлэх ажлыг оновчтой зохион байгуулах, нуугдмал хэргүүдийг илрүүлэх чиглэлээр “Судалгаа хяналт”, “Нуугдмал-2”, “Сар шинэ-2020”, “Хайр өвтгөдөггүй”, “Согтуу жолоочтой хамтдаа тэмцье”, “Байгалиа хамгаалъя”, “Аюулгүй ажиллагаа-Амьдралын баталгаа”, “Асар сан”, зэрэг 8 нэгдсэн, “Тулгалт”, “Асар сан”, “Хүүхдийн хүмүүжил”, “Согтуу”, “Хурд”, “Тээврийн хэрэгслийн үзлэг оношилгоо”, “Бойчин”, “Ачааны бүртгэл”, “Ченж” “Хяналт сүлжээ”, “Эргүүл шалгалт”, “Хуурамч мөнгө”, “Бүлэг бөөгнөрөл”, “Эмзэг цэг”, “Алдуул мал” зэрэг 30 хэсэгчилсэн арга хэмжээ, “Хууль сурталчлах”, “Хүүхэд хэрэглэгч” аян зэргийг төрийн болон төрийн бус</p>	100

				<p>байгууллагуудтай хамтран зохион байгуулсан.</p> <p>Нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ, аяны хүрээнд 103 удаагийн сургалт сурталчилгаа, уулзалт хэлэлцүүлэг 19, цахим уралдаан 2, нийт 124 арга хэмжээнд 23380 төрийн болон төрийн бус байгууллагын ажилтан, албан хаагч, иргэд оролцсон байна.</p> <p>Гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулах мэдэгдлийг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд 230 хүргүүлж, үүнээс 185 мэдэгдлийн хариуг авч, биечлэн газар дээр 42 мэдэгдлийг шалгаж, хариу ирүүлээгүй 1 иргэнийг 100.0 төгрөгөөр торгосон байна.</p>	
4	<p>Цагдаагийн байгууллагын алба хаагчдын ёс зүйн харилцааны талаар иргэдийн сэтгэл ханамжийн судалгаа авч, санал дүгнэлтэд үндэслэн цагдаагийн алба хаагчдын харилцаа хандлагыг дээшлүүлэх сургалтад хамруулах</p>	<p>Алба хаагчдын сахилга хариуцлага ёс зүйн чиглэлээр иргэдээс сэтгэл ханамжийн судалгааг авч, үнэлэлт дүгнэлт өгөх</p>	Жилдээ	<p>2020 оны эхний хагас жилийн байдлаар 24 алба хаагч зөрчил гаргаж, сахилгын арга хэмжээ авагдсан нь урьд оны мөн үетэй харьцуулахад 1 нэгжээр буюу 16 хувиар буурсан байгаа ба бүртгэгдсэн зөрчлийг хэлбэрээр нь ангилбал: ажлын хариуцлага алдсан 12 буюу 50 хувь, архидан согтуурсан 1 буюу 4,1 хувь, ЭХХШТХ тогтоомж зөрчсөн 3 буюу 12.5 хувь, Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм зөрчсөн 5 буюу 20,8, үүрэг даалгавар үл биелүүлсэн 3 буюу 12,5 хувь байна. Сахилгын зөрчил гаргасан алба хаагч нийт бүрэлдэхүүний 11 хувийг эзэлж байгаагаас офицер бүрэлдэхүүн 18 буюу 75 хувь, ахлагч бүрэлдэхүүн 6 буюу 25 хувийг</p>	100

			<p>эзэлж байна. Нийт зөрчлийн 9 буюу 37.5 хувийг дотоод хяналт шалгалтаар илрүүлсэн.</p> <p>Сахилга ёс зүйн зөвлөлөөс 2020 онд сахилга хариуцлагын зөвлөгөөнийг нэгдсэн байдлаар 2, хэсэгчилсэн байдлаар 1 удаа цахимаар зохион байгуулсан ба уг зөвлөгөөнүүдэд давхардсан тоогоор 185 алба хаагч хамрагдсан. Зөвлөгөөнөөс "Цагдаагийн газрын 2020 оны албаны сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, заавал судлах хууль эрх зүйн акт, цахим болон зайны хэлбэрээр өгч байгаа сургалтуудыг бие даан судалж, хууль эрх зүйн мэдлэг, ур чадвараа дээшлүүлж сахилга ёс зүйн зөрчилгүй хамтдаа урагшильъя" уриалга дэвшүүлснийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган ажиллаж байна.</p> <p>Алба хаагчдыг сахилга, ёс зүйн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх зорилгоор тус газрын хэмжээнд энэ оны 03 дугаар сарын 04-ний өдрөөс 04 дүгээр сарын 04-ний өдрийн хугацаанд "Сахилга, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлж, хамтдаа урагшильъя" аяныг зохион байгуулж, аяны хүрээнд "Ажлын бүтээмжийг дээшлүүлье" сэдэвт шинэ санал санаачилгын "ЭССЭ" бичлэгийн уралдаан, "Инээмсэглэл нөхөрлөлийг бий болгоё", "Авлигагүй орчин" аяныг зохион байгуулж, Цагдаагийн ерөнхий</p>	
--	--	--	---	--

				газраас эрхлэн гаргасан гаргасан “Өөрийгөө дайчилж чадвал амжилтад хүрдэг” номыг хэлтэс, тасгийн алба хаагчдын дунд аялуулан номын тэмдэглэл хөтлүүлсэн.	
5	Иргэдийн амгалан тайван байдлыг хангахад чухал шаардлагатай техник хэрэгсэл авах /хурд хэмжигч 2ш, аж ахуйн нэгжүүдийн камерт хяналт тавих хэрэгсэл/ хөрөнгийг татвар давсан орлогоос болон 2021 оны төсвийн төсөлд тусгах талаар анхаарал тавьж хэрэгжүүлэх	Цагдаагийн байгууллагын ажил, үйлчилгээнд шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн судалгааг гарган холбогдох газарт санал хүргүүлж шийдвэрлүүлэх	Жилдээ	Тус газарт 2014 онд орон нутгийн хөрөнгөөр 249.000.000 төгрөгийн хөрөнгө оруулалтаар гудамж, талбайн хяналтын камер суурилуулж ашиглалтад оруулсан. Дээрх камеруудын ашиглалтын хугацаа дуусаж шаардлага хангахгүй болсон ба дахин камержуулах зорилгоор Хууль зүй, дотоод хэргийн яамнаас камержуулах төслийн хүрээнд тус аймаг нь камержуулсан жишиг аймаг болохоор судалгаанд хамрагдсан. Мөнгөнморьт, Баянчандмань, Цээл, Угтаалцайдам сумдад орон нутгийн хөрөнгө оруулалтаар гудамж замын камертай болсон. Зуунмод сумын дэлгүүр үйлчилгээний газрууд ойр орчмоо камержуулах ажлыг хэрэгжүүлж нийт аж ахуйн нэгжийн 90 орчим хувь нь хяналтын камертай болсон. Төв аймгийн Бүрэн суманд 14, Эрдэнэсант суманд 2, Заамар суманд 5, Борнуур суманд 4, Сүмбэр суманд 2 камер шинээр байрлуулахаар техник эдийн засгийн үнэлгээ хийгдсэн байна. Аймгийн Гэмт хэргээс урьдчилан	90

			<p>сэргийлэх ажил зохицуулах зөвлөлд Зуунмод суманд шинээр 10 цэгт камер байрлуулах тоног төхөөрөмжийн төсвийг танилцуулан 5 сая 470,0 мянган төгрөгийн хөрөнгийг шийдвэрлүүлсэн.</p> <p>Тус газрын Эрүүлэхх саатуулах байрны өргөтгөлийг хийлгэхээр аймгийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгаж хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлж байна.</p>	
--	--	--	--	--

Нийт 5 ажил үйлчилгээ, хэрэгжилт 92 хувь

БИЕЛЭЛТ НЭГТГЭСЭН:
ТӨЛӨВЛӨЛТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ ХАРИУЦСАН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН, ЦАГДААГИЙН ХОШУУЧ

Х.ЦЭНДСҮРЭН

ТАНИЛЦСАН: ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА Б.ГАНЗОРИГ